



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 26 өдөр

Дугаар А/92

Булган сум


“Ойн жил”-ийг зохион байгуулах ажлын хэсгийг томилох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2021 оны 58 дугаар зарлиг, Засгийн газрын 2020 оны “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 24 дүгээр тогтоол, Засгийн газрын 2021 оны “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний талаар авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 350 дугаар тогтоол, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын “2024 оныг Ойн жил болгон зарлах тухай” 2023 оны А/654 дүгээр тушаал, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны XIX дүгээр Хуралдааны XIX/05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг эрчимжүүлэх зорилгоор 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд “Ойн жил”-ийн ажлыг зохион байгуулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар томилсугай.

2.“Ойн жил”-ийг чанарын өндөр түвшинд зохион байгуулж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга (А.Гантөмөр)-д, хяналт тавьж ажиллахыг аймгийн Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Г.Давааням)-д үүрэг олгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

Аймгийн Засаг даргын 2024. оны
02 дугаар сарын 26-ны өдрийн А/92 дугаар
захирамжийн хавсралт



"Ойн жил"-ийн ажлыг зохион байгуулах
ажлын хэсгийн бүрэлдэхүүн

- Ажлын хэсгийн дарга: А.Гантөмөр (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга)
- Гишүүд:
- Г.Бямбажаргал (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)
 - Б.Алтансүх (Булган сум дундын Ойн ангийн дарга)
 - М.Нямжаргал (Хялганат сум дундын Ойн ангийн дарга)
 - Ш.Даваахүү (Хутаг-Өндөр сум дундын Ойн ангийн дарга)
 - Г.Сүхбат (Тэшиг сумын Ойн ангийн дарга)
 - Н.Мөнхсайхан (Бугат сумын Ойн ангийн дарга)
 - М.Амгалан (Ахмадын төлөөлөл)
 - Булган аймаг дахь ойн нөхөрлөлүүдийн холбоо
 - Аж ахуйн нэгжийн төлөөлөл
- Нарийн бичгийн дарга: Б.Отгонжаргал (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын ойн нэгжийн дарга)